

Монголын дэлгэцийн бүтээл дэх гээгний соёлын илэрхийлэл

Эрдэнэчулууны Нарангэрэл ✉

Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ naraa.makeup11@gmail.com

Дамдинсүрэнгийн Даваасүрэн 

Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Хүн чулуун хөшөөд, археологийн олдвор, түүхэн баримт сэлт нь дэлгэцийн бүтээлийн дүрүүдийг тодотгох боломжийг нээж өгч байна. Уламжлалт үсний хэлбэр, засал, өнгө, бүтэц бүхий элементүүд нь домог, бодит үйл явдлаас сэдэвлэсэн, түүхийн кино зэрэгт дүрийн сэтгэл зүй, зан төлөв, нийгмийн байр суурийг илэрхийлэх дүрслэлийн хэлийг бий болгох магадлалтай болно. Үс гээг нь дэлгэцийн бүтээлийн соёлын илэрхийлэл, дүрийн сэтгэлийн хөдөлгөөнийг нэгтгэсэн бүтээлч ажиллагаа. Үс гээгний хэлбэр засалт нь утга бэлгэдлийн хувьд шинэ түвшинд гарч үзэгчдэд түүх, нийгэм цаг үеийн соёлыг уран сайхны дүрээр дамжуулан таниулах боломжийг нэмэгдүүлж байна. Түүхэн сэдэвт уран сайхны киноны эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн үс гээгний хэлбэр загвар нь тухайн цаг үеийн хүмүүсийн соёл, нийгмийн гарал, угсаа, эрх мэдэл, шашин шүтлэг мөн уламжлалыг хадгалсан нь судалгаанаас харагдаж байна.

Түлхүүр үгс: нүүр хувиргалт, кино, гээгний засал, дүрийн дүрслэл, бэлгэдэл

Cultural Expression of Hairstyles in Mongolian Screen Productions

Narangerel Erdenechuluun ✉

School of Theater Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ naraa.makeup11@gmail.com

Davaasuren Damsinsuren 

School of Theater Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: Stone monuments, archaeological findings, and historical sources open up possibilities for enriching and defining characters in screen productions. Elements based on traditional hairstyles—their forms, arrangements, colors, and textures—create

visual codes that express a character's psychology, personality, and social status in films inspired by legends, real events, and history. Hair and hairstyling function as a creative practice that integrates cultural expression and the emotional states of characters in cinematic works. The forms and styles of hair have reached a new level of symbolic meaning, enhancing the audience's understanding of history, society, and the spirit of a given era through artistic representation. Research shows that the hairstyles of male, female, and child characters in historical feature films preserve and reflect the culture, social origin, ethnicity, rank, power, and traditions of the people of the depicted period.

Keywords: *makeup, cinema, hairstyle designs, character representation, symbolism*


Оршил

Нүүр хувиргах урлаг технологийн дэвшил, эрүүл ахуй, гоо зүйн шинжлэх ухааны нөлөөгөөр шинэчлэгдэж байна. Гэвч дэлгэцийн бүтээлд нүүр хувиргахыг гоёл чимэглэл төдий авч үзэх хандлага байсаар л байна. Энэ нь уг урлагийн уран сайхны үүргийг илэрхийлж чадахгүйд хүрч байна. Судлаачид үзэхдээ, нүүр хувиргах нь уран сайхны дүрийн тухай мэдээллийг үзэгчдэд дамжуулах үүрэг бүхий тайз, дэлгэцийн урлагийн салшгүй бүрэлдэхүүн гэснийг орхигдуулж болохгүй.

Иймд, тухайн уран бүтээлийн агуулгад нийцсэн дүрийн сэтгэл зүй, зан төлөв, цаг хугацаа, уур амьсгалыг илэрхийлдэг уран сайхны нүүр хувиргах аргачлалыг онолын болон хэрэглээний түвшинд гүнзгийрүүлэн судлах шаардлага бидний өмнө тулгамдаж байна.

Хиймэл үс, гэзэгний хэлбэр загварын түүхээс авч үзвэл, 1993 онд оросын түүхийн ухааны доктор Наталья Викторовна Полосьмак Алтайн нурууны Үхгийн ууланд пазырыкийн гэж нэрлэгдэх булшинд малтлага хийх явцад НТӨ 300 жилийн тэртээ занданшуулсан залуу эмэгтэйн шарил (муми) олжээ. Үүнийг судлаачид “Гүнжийн булш” хэмээн нэрлэсэн.

Уг археологийн олдвороос “...ноосон цамц, ноосон банзал, эсгий оймс, арьсан дээл (шуба), мөн **хиймэл үс** (парик) олдсоноос гадна зүүн гарын хажууд гоо сайхны уут байсан. Сонирхолтой нь маш сайн хадгалагдсан адууны хялгасаар хийсэн нүүр будгийн багс, мөн харандаа маягийн зүйл байжээ. Уг зүйлийн иш нь төмрөөр хийгдсэн. Харин үзүүр нь төмрийн исэл агуулсан тул арьсан дээр хар ногоон өнгөөр зурж болдог байсан байна. Гүнжийн зүүн мөрөн тушаа шивээстэй болно...” (Шужун 2012). Энэ олдвор нь тухайн цаг үед эмэгтэйчүүд хиймэл үсийг ахуй амьдралдаа хэрэглэж байсан түүхийн ул мөр болно (Зураг 1). Энэ талаар хятадын өдөр тутмын сонинд Шужун Ма өгүүлэл нийтүүлж, хиймэл оюун ухаанаар зургийг бүтээжээ (Зураг 2).



Зураг 1. Гүнжийн булш¹

Зураг 2. Шүжун Ма-ийн хиймэл
оюун ухаанаар бүтээсэн зураг²

Монголчуудын үс гэзэгний загвар Монгол нутагт хөшөө чулуудад дүрслэгдэн үлдсэн байдгийн нэгэн жишээг дурдвал, Сүхбаатар аймгийн Дарьгангын нутгаас олдсон. Их Монгол улсын үеийн Ламтын хэмээх хүн чулуудад тухайн үеийн эрчүүдийн үс гэзгийг **хоёр чихний араар багцлан боож унжуулсан үс, мөн дух руу унжуулсан хөхөл үстэй** байгаагаар дүрсэлжээ (Зураг 3).



Зураг 3. Хүн чулууд



Зураг 4. “Эзэн хаан ба хатан хаан Табиз ордныг
хүлээн авч буй нь” зургийн баруун доод булан

Рашид ад-Дин тэргүүтэй хүмүүсийн бичиж, зурж үлдээсэн “Судрын чуулган”-д “Эзэн хаан ба хатан хаан Табиз ордныг хүлээн авч буй нь” зургийн баруун доод хэсэгт ордонд байх XIII зууны эрчүүдийн үс гэзэгний хэлбэр шивэлгэрийг дүрслэн үзүүлсэн байна (Зураг 4).

Эрдэмтэн судлаач Э.Оюун Дорноговь аймгийн Зүүнбаян суманд 1958 онд хийсэн Говийн V ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн “Нүүдлийн театр”-ын судалгаандаа “... жүжигчид өөрсдөө нүүр будгаа

¹ https://www.chinadaily.com.cn/hqzx/2012-09/06/content_15736808_2.htm

² https://www.chinadaily.com.cn/hqzx/2012-09/06/content_15736808_2.htm

хийдэг байжээ. *Хиймэл үс, хууз сахал, сахал* хэрэглэдэг. Харин хиймэл үс, хууз сахал, сахал байх шаардлагатай үед жүжигчид өөрсдөө адууны хялгас, сарлагийн сүүл зэргээр хийдэг байсныг санаж байв...” (Оюун 2021, 13-15).

Мөн Д.Равжаагийн “Саран Хөхөөний намтар”-ын шинжлэл судалгаандаа С.Хөвсгөл доктор (Ph.D) жүжигчдийн нүүр хувиргалтад ямааны сахлаар *хиймэл үс, сахал* хийдэг байсан тухай дурдсан байна (Хөвсгөл 2023, 82).

Дээрх хоёр судалгааны эшлэлээс үзэхэд Данзанравжаагийн нүүдлийн театрт дүрийн нас, хүйсийг тодотгохын тулд хиймэл үс, сахлыг малын хялгас, сүүл, савгаар хийдэг байсан нь тодорхой юм.

Энэхүү өгүүлэлдээ дэлгэцийн урлагийн нүүр хувиргалтад үс гэзгийг хэрхэн үзүүлсэн туршлагыг тухайлан авч үзэв.

Дээр дурдсан бүтээлүүдээс гадна “Эх бүрдийн домог”-ийн хаан, “Бушхүүгийн үлгэр”-ийн Бушхүү, “Цэц магнай”-н Шагай, “Бүлээн нурам”-ын эцэг, залуу хоёр, “Мандухай цэцэн хатан”, “Алтан шонхор”, “Үхэж үл болно-Чингис хаан”, “Аравт”, “1242-Өрнөдийн босгон дээр” гэх зэрэг киноны дүрээс XIII зууны үеийн монгол эрчүүдийн дух руу орсон туг үс буюу *хөхөл*, оройн хэсэгт сүлжсэн үс буюу *гөрмөл*, тэгш хоёр хуваан гогцоо гарган багцлан боосон үс буюу *шивэлгэр* зэрэг үсний хэлбэр, засалтыг бэлээхэн харж болно.

Судалгааны арга зүй

Судалгааны түүхэн сурвалж судлалд монгол үс гэзэгний соёлын уламжлалт агуулгыг баримтлан шинжилсэн. Мөн бэлгэдэл зүй болон урлаг судлал түгээмэл тайлан тайлбарлах арга зүйг судлаачдын бүтээлд тулгуурлан ашигласан. Энэ нь дэлгэцийн бүтээлийн дүрүүдэд шингэсэн киноны хэл болон бэлгэдлийн утгыг тодруулахад чиглэж буй юм.

Судалгааны үр дүн

Кино урлагийн уран сайхны илэрхийллийн салшгүй нэгэн хэсэг нь жүжигчний үс гэзэг юм. Гэзэг нь дүрийн гадаад төрх төдийгүй, үндэс угсаа, нийгмийн байр суурь, шашин шүтлэг, дотоод сэтгэл, зан төлөв, хүйсийн ялгаа, он цагийн хэлхээсийг илэрхийлэх код, бэлгэдлийн үүрэгтэй байдаг. Энэ утгаараа үс гэзэг, түүний байршил, хэлбэр, засалт, өнгө, бүтэц нь кинонд уран сайхны дүрийг тодотгох нэгэн төрлийн хэл мөн. Бид энэхүү өгүүлэлдээ дараах монголын уран сайхны кинонд үс гэзгийг хэрхэн хэрэглэснийг авч үзэв. Үүнд: “Цогт тайж” (1945, МУСК), “Өглөө” (1968, МУСК), “Талын цуурай” (1969, МУСК), “Тунгалаг тамир” (1970-1973, 3 бүлэг, МУСК), “Мөнх тэнгэрийн хүчин дор” (1992, 3 бүлэг, МУСК), “Төөрөг” (1993, МУСК), “Догшин хутагтын сахиус” (1997, МУСК), “Содура” (2015, МУСК), “Надад ирээгүй хайр” (2025, МУСОАК).

Нэг. Монголын уран сайхны “Мөнх тэнгэрийн хүчин дор” киноны нүүр хувиргагчаар Д.Бадамцэрэн, М.Одончимэг, Д.Дагирмаа нар ажилласан. Түүхэн сэдэвт “Мөнх тэнгэрийн хүчин дор” кинонд их эзэн Чингис хааны үсийг хоёр хуваан үзүүр хэсгийг таван гогцоотойгоор багцлан хийсэн нь хаан язгууртан болохын бэлгэдэл юм. БНХАУ-д бүтээгдсэн “Чингис хаан” (2004 он), “Үхэж үл болно-Чингис хаан” (2008 он) кинонд үүнтэй ижил байна. Хөхөл нь гуравдагч мэлмийг хамгаалах, алаггүй тэгш үзэх ёсыг харуулсан бөгөөд Чингис хааны

дүрээс гадна, Жамухын үсийг таван гогцоотой харуулсан нь түүнийг “Гүр хаан” байсантай холбон тайлбарлаж болно (Зураг 5, 6).



Зураг 5. Чингис хаан - А.Энхтайван



Зураг 6. Жамух - Ц.Төмөрбаатар

Монгол соёл дахь тавын тооны бэлгэдлийг эмхлэн үзвэл, ертөнцийн үүслийн домогт таван өнгө, таван зүг, таван махбодоор ертөнцийн дотоод бүтцийг бэлгэдэх хийгээд үүгээрээ тавын тоо бол зурхайн тоо, дотоод тоо болно. Тооны бэлгэдлийн цогцолборт тавын тоо нь босоо хэвтээ тэнхлэгийн уулзвар болдог нь анхны тэгш тоо-хоёр, анхны сондгой тоо гурвын нийлбэр байдгаас болжээ. Тэр дундаа уран



Зураг 7. Өгөөдэй - У.Энхбаяр

зохиол, үлгэр туульд таван өнгө хэмээх нь уран тансгийн бэлгэдэл, ер бишийн бодгал хүн мэндлэхийн бэлгэдэл болдог. Монголын уламжлалт соёл сургаал, хүмүүний номд тавын тоо нь (таван мөс, таван гал) эв эеийн хүчин бүрдлийг бэлгэддэг ажээ (Дулам 2025, 721). Уг киноны хан хөвүүд, отгийн толгойлогч, жанжин, ордны мэргэд зэргийн дүрийн үсийг чихний тушаа хоёр хуваан сүлжин боосон гогцоог гурваар багцлан үзүүлсэн байна (Зураг 7).

Гурван гогцоот гэзэг нь төрийн хүмүүн ба мэргэд түшмэл, жанжин гэсэн утгыг илэрхийлдэг бол, нэг гогцоо нь энгийн хүмүүний гэзгийн засал байжээ. Ер нь судлаачдын тэмдэглэснээр “Монголчуудын хувьд гурав бол хамгийн анхны олныг төлөөлсөн сондгой тоо, аргын арга тоо учраас ямагт үл тэгширч, цаашлан өсөж олширч байхын чанад утгыг агуулах төдийгүй аливаа үйлийн бүрэн бүтэн, төгс төгөлдрийн бэлгэдэл болдог. Тиймээс, Монгол үндэстний ижилслийг илтгэх гол тоо нь гурав (3), түүнийг гурав дахин олшруулсан тоо болох ес (9)-ийн тоо юм. Түүхэн уран зохиолд буй гурвыг хувь хэмээх үзэл, туульсын баатруудын албат ир хошууч, баатар, мал хөрөнгийг гурваар хувилах, бэлгэшээх ёс, монгол домогт хүн амьтны насны хэмжлийг гурваар цаглах ёс нь аливаа тоо хэмжээг гурваар хувилах буюу чанагш үржих олшрохуйг бэлгэднэ” (Дулам 2025, 248).



*Зураг 8. “Цогт тайж” киноны
Ли Сан Син - Д.Чимэд-Осор*

Хоёр. Монголын уран сайхны “Цогт тайж” киноны гримерт Бадамханд, Маслова, Долгор нар ажилласан. Тус киноны цэцэрлэгч өвгөн Ли Сан Сины дүрийг бүтээсэн Дэндэвийн Чимэд-Осор (1912-1987) “Би залуухан 32, 33-тай л байж. Энэ өндөр настай хүний ролийг анх авахад алхах гишгэх түргэдээд чогжигноод байх, дуу хоолой шингэдээд залуудаад байх явдал тохиолдсон” хэмээсэн байдаг. Мөн тэрээр хувцас өмсөх, таяг гэх мэтийг барих бариулах, урт цагаан сахал наах гэх мэт нүүр тэргүүтэй гадаад төрхийг өөрчилсөн, гол нь дүрийг тодорхойлон бүтээхэд гаднах хэлбэрээс сэтгэл, дотоод ертөнцөөс нь эхэлдэг гэдгийг ч онцолсон.

Хэдийгээр сахал нааж, таяг бариулсан хэдий ч, уг киноны хувьд “цэцэрлэгч өвгөний хэлж байгаа үг яриа, түүний хүсэж байгаа хүсэл мөрөөдөл энэ бүх зүйлээс харахад залуу зандан насны хүн биш, харин нэлээн өндөр настай, их соёлтой бичгийн хүн болохыг илэрхийлсэн” гэж тэрээр үзжээ (Лувсанвандан 1989, 46).

Гурав. Монголын уран сайхны “Өглөө” киноны нүүр хувиргагчаар Д.Найданжав, Ю.Емельянов нар ажилласан байна (Зураг 9). Монголын уран сайхны “Тунгалаг тамир” киноны нүүр хувиргагчаар Б.Баяржаргал ажилласан (Зураг10). XX зууны эхэн үеийн монголын хөдөө нутгийн дүр төрх, эрх чөлөөний төлөөх тэмцэл, шинэ нийгмийн харилцаа ард олны оюун санаанд гарсан өөрчлөлт зэргийг туульсын хэлбэрээр тусган харуулсан “Тунгалаг тамир” монголын уран уран сайхны кинонд тухайн үеийн эхнэр үс болон тав гээгний соёлыг тодорхой харуулсан.



*Зураг 9. “Өглөө” киноны
Бадам - М.Бадамгарав*



*Зураг 10. “Тунгалаг тамир” киноны
Эрдэнэ - Н.Баатар*


XVII зууны үе бол Манж дайчин улсад Монгол дагаар орж, улмаар манж хувцас, үсний хэв маяг монголчуудын соёл, сэтгэлгээнд нөлөө тусгалаа олсон үе юм. Тодруулбал, “Монгол эрчүүд манж маягийн тав гээг тавьж, нөхөрт гарсан

эмэгтэй хүн үсээ хоёр хувааж дугуйруулан дэрийлгэж хавчих болсноор “эхнэр үс” бий болж, түүнийг тогтоох толгойн боолт, үсний хавчаар, үсний гэр зэрэг хэрэгслүүд үүсэж түүнийгээ цалин цагаан мөнгөөр уран нарийн хийцтэйгээр урладаг болжээ. Бэл бэнчнээсээ хамааран 5-20 кг хүртэл мөнгө хэрэглэдэг байсан” (Уранчимэг 2015, 45-46) талаар судлаачид тэмдэглэсэн.

Дөрөв. Монголын уран сайхны “Төөрөг” киноны нүүр хувиргагчаар Д.Найданжав ажилласан. Д.Нацагдорж, Б.Дамдинсүрэн “Учиртай гурван толгой” дууриас сэдэвлэн бүтээсэн дуулалт киноны олны хэсэгт (масс) зуны дэлгэр цагаар хөрөнгө чинээтэй хот айлын гадаа эсгий хийх үйлэнд эцэг эхээ даган ирсэн хүүхдүүдийг эвэр үстэйгээр дүрслэн үзүүлсэн байна (Зураг 11).



Зураг 11. “Төөрөг” киноны олны хэсэг




Зураг 12. Хүлээлтийг илтгэх үс

Хүүхдийн даахь авах үед байх ёстой хүмүүс ирж амжаагүй тохиолдолд хоёр эвэр үс үлдээдэг. Мөн нэг эвэр үс үлдээх нь тухайн хүүхдийн аашийг номхотгох ардын дом ажээ (Зураг 12) (Гэрлийн өргөө 2022, 132).

Тав. Монголын уран сайхны “Догшин хутагтын сахиус” киноны нүүр хувиргагчаар Л.Энхтуяа ажилласан. Данзанравжаагийн бага насанд Б.Билгүүн тоглосон (Зураг 13). Зарим судалгааны үр дүнгээр бол Хутагтын бага насны дүрийн гэзгийг Зураг 14-т буйгаар зассан бол урьд насны дурсамжийг хадгалах гэх утгаараа илүү нийцтэй болох байсан болов уу гэж бид үзэж байна.



Зураг 13. Хутагтын бага нас



Зураг 14. Урьд насны дурсамжийг илтгэх үс

Зургаа. Ардын хувьсгалын 50 жилийн ойд зориулан 1969 онд бодит түүхээс сэдэвлэн монгол кино үйлдвэрт бүтээгдсэн “Талын цуурай” уран сайхны киноны нүүр хувиргагчаар Д.Бадамцэрэн ажилласан. Богд хан аймгийн Шанхай уулын хошууны Дарь бүсгүй эвлэлийн үүрийн даалгавраар ухуулга хийж яваа хэсэг нөхөдтэй таарч улмаар тэдний эгнээнд элсэн орж гурваар дарсан урт гэзгээ тайруулна. Уг кинонд дүрийн үзэл санааны өөрчлөлтийг эмэгтэйчүүдийн үсний засалтаар тодорхой харуулсан хэмээн тайлбарлаж болно (Зураг 15).



Зураг 15. “Талын цуурай” киноны Дарь - Л.Тунгалаг

1921 оны Ардын хувьсгалын дараа эмэгтэйчүүд нь эхнэр үсийг халж үсээ нэг сүлжин угт нь сувдан даруулга, сувдан сам хэрэглэх мөн хувьсгалт залуучуудын эвлэлийн гишүүн болж үсээ тайрах болжээ. Эрэгтэйчүүд нь орос цэргийн үс засалтын нөлөөгөөр тав гэзэг тавихаа больж гэзгээ тайрч, үсээ ургуулан богиносгон засдаг болсон байна (Уранчимэг 2015, 52).



Зураг 16. “Содура” киноны олны хэсэг

Долоо. UBS телевизийн хамт олны бүтээл “Содура” нь бүрэн хэмжээний уран сайхны драм төрлийн 2015 онд бүтээгдсэн кино. Уг киноны нүүр хувиргагчаар Г.Ганчимэг ажилласан байна. Монголын их тайгын цаатан ардын аж амьдрал, зан заншил, соёл суртахуун төдийгүй тэдний өмнө тулгамдаж буй хурц эгзэгтэй асуудлыг харуулахын зэрэгцээ өв уламжиллаа хадгалан үлдсэн дүрслэлийг нэлээд дэлгэрэнгүй үзүүлдэг. Үсийг задгай тавих нь хүн нас нөгчсөн гашуудлыг илтгэх цээрлэх ёсыг харуулсан байна (Зураг 16).

Найм. ОХУ-ын “И все-таки я люблю” цувралын албан ёсны монгол хувилбар болох 2025 онд бүтээгдсэн “Надад ирээгүй хайр” олон ангит киноны нүүр хувиргагчаар Э.Аззаяа ажилласан. Дүрийн сэтгэл зүйн илэрхийллийг үс гэзгийн өөрчлөлт-тайван, эмх цэгцтэй хэлбэрээс сэгсийж, унах, тайрах зэрэг өөрчлөлт нь дүрийн сэтгэл зүйн шилжилтийг тодотгодог (Зураг 17).



Зураг 17. “Надад ирээгүй хайр” киноны Бүжин – Н.Нархажид

Бүжингийн дүрийн сэтгэл зүйн төлөв байдлын өөрчлөлт болон амьдралын зам мөрийн өсөлт, уруудахыг даган үс хэрхэн өөрчлөгдөж буйг харж болно. Кино урлагт үс гээг нь зөвхөн гоёл чимэглэл бус, харин дүрийн дотоод ертөнцийг илэрхийлэгч хөдөлгөөнт элемент юм. Камерын өнцөг, гэрэлтүүлэг, өнгөний шийдэл, хөдөлгөөний хурд зэрэгтэй уялдан үс гээг нь дүрийн сэтгэл хөдлөлийг улам гүнзгий илэрхийлэх боломжийг олгодог.

Хэлэлцүүлэг

Сүүлийн жилүүдэд түүхэн кино олон улсад болон Монголд нэлээд бүтээгдэж байна. Энэхүү өгүүлэлд дүрийн гадаад төрхөд чухал нөлөө үзүүлэх үндэсний уламжлалт үс гээгний загвар хэлбэрт ажиглалт хийсэн болно.

Дэлгэцийн бүтээлийн дүрийн үс гээгний соёлын илэрхийлэлд хийсэн тусгайлах судалгаа байхгүй ч нүүр хувиргах урлагийн элемент болохын хувьд оросын эрдэмтэн М.Н.Максимова “Оросын театрын урлагийн нүүр хувиргалтын соёл XIX зуунаас XX зууны эхэн үе” (2010) сэдвээр урлагийн түүхийн доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан. Тус нэг сэдэвт эрдэм шинжилгээний бүтээлд театрын нүүр хувиргалт нь соёл, урлаг судлалын бараг судлагдаагүй салбар хэмээн онцлон тэмдэглээд цаашид шинжлэх ухаан болон практикийн түвшинд илүү нарийн судлах санааг дэвшүүлсэн байна. Архивын эх сурвалж (фото, эскиз, тэмдэглэл)-ийг шинжилж, театрын дүрийн визуаль хэлбэрийг тодорхойлсон. Нүүр хувиргалттай уялдуулан найруулагч, сурган хүмүүжүүлэгч К.Станиславский, Вл.Немирович-Данченко, Е.Вахтангов, Вс.Мейерхольд, А.Таиров нарын дэг сургалтуудын үзэл баримтлалтай холбон анх удаа тусгайлан шинжлэх ухааны үүднээс судлагдсан гэж үзэж болно. Нүүр хувиргалтыг анх удаа бие даасан урлагийн төрөл гэж тодорхойлсон. Хувиргалт нь жүжигчний дүр бүтээхэд хэрхэн “визуаль текст” буюу харах мэдрэмжээр дамжин үг болон хувирахыг нотолсон. Хувиргалт нь дүрийн нүүрний тоглолт (мимик), яриа зэрэгтэй нэгэн адил дүр бүтээх чухал элемент бөгөөд дүрийн сэтгэл зүйн шинж чанарыг илэрхийлэхэд тусалдаг хэмээн үзсэн.

Хятадын судлаач Цай Фэйлонг “Бээжин дуурийн нүүр будгийн дижитал загварчлал ба дүрслэх технологийн судалгаа” сэдэвт соёл судлалын доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан бүтээлдээ өнөө үед дэлхийн улс орнууд уламжлалт биет болон биет бус соёлын өвийг хамгаалах, хадгалах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой ач холбогдол өгч буйг өгүүлсэн. Иймд биет соёлын өвийг дижитал орчинд загварчлах, дүрслэх технологи нь судлаачдын сонирхлыг татах болсон. Бээжин дуурь нь

хятадын уламжлалт соёлын чухал өв бөгөөд түүний өвөрмөц нүүр будалт нь уг соёлын үнэт зүйлийн нэг юм хэмээжээ.

Энэхүү судалгааны үр дүн нь Бээжин дуурийн уламжлалт нүүр будалтыг дижитал орчинд сэргээн дүрслэх, хадгалах, цаашид өвлүүлэх шинэ арга зүйг санал болгож байгаа бөгөөд нүүрний хөдөлгөөн, илэрхийлэл, 3D дүрслэлийн технологийн хөгжилд онолын болон дадлагын чухал ач холбогдолтой судалгаа болсон хэмээн судлаачид дүгнэсэн байна.

Дүгнэлт

Хүн чулуун хөшөө, археологийн олдвор, түүхэн сурвалж баримтуудад тулгуурлан үзэхэд монголчуудын үс гэзэг нь зөвхөн ахуйн хэрэгцээ бус, нийгэм, соёл, бэлгэдлийн гүн утга агуулсан өвөрмөц соёлын илэрхийлэл байсныг тодорхой харуулж байна. Энэхүү судалгааны үр дүн нь орчин үеийн кино, театр, дэлгэцийн бүтээлд дүр бүтээх уран сайхны арга зүйг баяжуулах, дүрийн сэтгэл зүй, нийгмийн байр суурийг илүү нарийн тодотгох боломжийг нээж өгч байна.

Эрдэмтэн зохиолч Э.Оюун, доктор, профессор С.Хөвсгөл нарын судалгаанд дурдсанаар Говийн догшин хутагт Дулдуйтын Данзанравжаагийн нүүдлийн театрын “Саран хөхөөний намтар” жүжигт дүрийн нас, хүйс, нийгмийн шинжийг ялган тодруулах зорилгоор хиймэл үс, сахлыг ашиглаж байсан нь уран сайхны дүрийг үс гэзгээр тодотгох эхлэл гэж үзэх үндэслэлтэй.

Монголчуудын үс гэзэгний нарийн дэг жаяг нь төрийн эрх мэдэл, овог аймаг, отог нутгийн зохион байгуулалттай шууд уялдаатайгаар үүсэж, бэлгэдэлт сэтгэхүйн тогтолцоонд суурилан хөгжсөөр уламжлалт соёл болон төлөвшсөн. Үсний хэлбэр, засал, өнгө, бүтэц зэрэг элементүүд нь домог, түүхэн бодит үйл явдлаас сэдэвлэсэн кинонд дүрийн дотоод мөн чанар, зан төлөв, нийгмийн байр суурийг илэрхийлэх “код”-ыг бий болгож байна хэмээн үзэж болно. Тухайлбал, үс гэзэг нь:

- Киноны үйл явдлын түүхэн цаг хугацааг илтгэх;
- Дүрийн насжилт, амьдралын туршлага, ахуй хэв маягийг илэрхийлэх;
- Дүрийн нийгмийн давхарга, эрх мэдэл, сүр хүч, өсөлт бууралтыг тодруулах киноны хэл болдог.

Эдгээр шинж чанар нь үс гэзэгний уламжлалт соёлыг дэлгэцийн бүтээлийн дүр бүтээх чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, үс гэзэг нь зөвхөн гадаад хэлбэр бус, бэлгэдлийн дүрслэл (symbolic image) болж, дүрийн гадаад төрх, сэтгэл зүйн орон зай, соёлын орчныг холбосон уран сайхны элемент болон оршиж байна.

Судалгааны үр дүнгээс харахад уран бүтээлчид үс гэзэг засах, чимэглэх, хэлбэрийг оновчтой сонгож ашигласнаар тухайн дүрийн баатарлаг шинж, нийгмийн орчиндоо үзүүлэх нөлөө, тухайн цаг үеийн онцлогийг цогцоор нь илэрхийлэх боломж бүрддэг. Ингэснээр үс гэзэг нь дэлгэцийн бүтээлд соёлын илэрхийлэл, уран сайхны хэл, сэтгэлийн хөдөлгөөнийг нэгтгэсэн бүтээлч ажиллагааны түвшинд хүрч байна.

Театр болон олон нийтийн урлаг, соёлын үйл ажиллагаанд нүүр хувиргалт технологийн хувьд дэвшилттэй хөгжихийн зэрэгцээ утга бэлгэдлийн хувьд орчин үеийн үзэгчдэд түүх, нийгэм, цаг үеийн соёлыг уран сайхны дүрээр дамжуулан танин мэдэх боломжийг олгож байна.

Иймд монголчуудын уламжлалт үс гэзэгний соёлыг судалж, дэлгэцийн бүтээлд үндэслэлтэйгээр үзүүлэх нь дэлгэцийн уран бүтээлийн чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой гэж дүгнэж байна.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Гэрлийн өргөө. 2022. *Хамаг монголын эзэнт улсын ур дүй ухаан урлалын онцлог.* Эмх. Дуламсүрэн Л. Улаанбаатар: Адмон.

Дулам, С. 2025. *Монгол соёлын тайлбар толь бичиг.* Улаанбаатар: Нандир.

Оюун, Э. 2018. *Монголчуудын театрын урлагийн ардын үндсүүд.* Улаанбаатар.

Уранчимэг, Ө. 2015. *Нүүр хувиргалтын үндэс.* Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Хөвсгөл, С. 2023. *“Саран хөхөөний намтар” шинжлэл.* Улаанбаатар.

ШУА. 1989. *Монгол кино урлаг.* Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.

Гадаад хэлээр:

Максимова, М.Н. 2010. “Оросын театрын урлагийн нүүр хувиргалтын соёл XIX зуунаас XX зууны эхэн үе.” Урлагийн түүхийн доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Москва.

Цай Фэйлонг. 2011. “Бээжин дуурийн нүүр будгийн дижитал загварчлал ба дүрслэх технологийн судалгаа.” Соёл судлалын доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. БНХАУ-ын Чжэжян их сургууль.

Шужун Ма. 2012. “Гүнжийн булшийг олсон тухай Шужун Магийн мэдээлэл.” *Хятадын өдөр тутмын сонин*, 2012.09.06. <https://cn.chinadaily.com.cn/>.

Кино:

Ванган, Л., Чимид, Ч. (зох.), Жигжид, Д. (найр.) 1968. *Өглөө.* Монгол кино үйлдвэр. 1 цаг 27 минут. Хар цагаан. <https://www.youtube.com/watch?v=jR8yn5oo5LY>.

Ванган, Л., Дашдооров, С. (зох.), Цэрэндорж, Ц. (найр.) 1970. *Талын цуурай.* Монгол кино үйлдвэр. 1 цаг 7 минут. Хар цагаан. <https://www.youtube.com/watch?v=KjQtzikU9VA>.

Догмид, Б. (зох.), Нямгаваа, И. (найр.) 1997. *Догшин хутагтын сахиус.* 1 цаг 42 минут. Өнгөт. <https://www.youtube.com/watch?v=cd-P1lclU1Q>.

Долгорсүрэн, Ч., Доржпалам, Р. (зох.), Доржпалам, Р. (найр.) 1970-1973. *Тунгалаг тамир 3 анги.* Монгол кино үйлдвэр. 4 цаг 26 минут. Хар цагаан. <https://www.youtube.com/watch?v=RK0GUy-j1d8>.

Маам, Д., Эрдэнэ, С., Батбаяр, Д. (зох.), Балжинням, Б. (ер.найр.) 1992. *Мөнх тэнгэрийн хүчин дор (3 анги).* Монгол кино, Чингис фильм. 3 цаг 49 минут. <https://www.youtube.com/watch?v=X8xMD9hEyEU>.

Отгонбат, Н., Наранбат, Б. (ер.прод.) 2025. *Надад ирээгүй хайр (Олон ангит)*. Nomadia pictures, Hulegu pictures. HD.

Ринчен, Б. (зох.), Юрий Тарич (найр.) 1945. *Цогт тайж 2 анги*. Монгол кино үйлдвэр. 2 цаг 43 минут. <https://www.youtube.com/watch?v=pPNvcQQhL4E>.

Сумьяа, С. (зох.), Балхжав, Л. (ер.прод.) 2015. *Содура*. UBS телевиз. 1 цаг 55 минут. HD.